

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
**/2022.06.06-2022.06.10/**

2022.06.06

Дархан хот

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилгын чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>- “Төвийн бүсийн барилга экспо-2022”-г 2022.05.28-29-ны өдрүүдэд 40 аж ахуйн нэгж байгууллагыг оролцуулан зохион байгуулсан. Үүнээс Улаанбаатар болон Эрдэнэт, Сэлэнгээс 12, орон нутгаас 28-н байгууллага оролцсон.</li> <li>- “Дархан-хот байгуулалт барилга Захиалагчийн газар” ОНӨААТҮГАЗАР ирүүлсэн Дархан-Уул аймаг, Хонгор сумын 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийн дагуу хянаж үзэхэд барилгын улаан шугамын акт дутуу байсан тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн.</li> <li>- Барилгын хөгжлийн төвөөс Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 онд ашиглалтад орсон болон 2022-2024 онуудад ашиглалтад орох нийтийн орон сууцны судалгаа ирүүлсэн маягтын дагуу хариуг албан бичгээр хүргүүлсэн.</li> </ul>
2	Инженерийн дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> <li>✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, МХГ-ын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж ХБТХОХ-т хүргүүлсэн.</li> <li>✓ ГЗБГЗЗГ-ын даргын албан даалгаварын хэрэгжилтийг гаргаж хүргүүлсэн.</li> </ul>
3	Барилгын материал чиглэлээр	<p>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.04.12-ны өдрийн 01-А/96 захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж орон нутгийн өмчит 95 байгууллагын 245 газар эзэмших эрх болон газрын суурь үнэлгээг 2021 оны санхүүгийн тайланд үнэлсэн үнэлгээг 2022.05.10-2022.05.30-ны хооронд шалгаж тооллоо. 245 газраас 88 газрын 33.6 тэр бум төгрөг /33 649 044 400/-ийн зөрчлийг илрүүлж ажилласан.</p> <p>Үүнээс Санхүүгийн тайланд <b>дутуу</b> үнэлж оруулсан 75 газрын 9.1 тэр бум төгрөг /9 064 097 400/, <b>илүү</b> үнэлсэн 13 газрын 24.5 тэр бум төгрөг /24 584 947 000/-ийн зөрчил гарсан. Мөн 237 барилга байгууламжийн ашиглалтанд орсноос хойш хувийн хэрэг хөтлөлт, газрын гэрчилгээний цахим код авч шинэчилсэн эсэх, газрын кадастрт барилга байгууламжийн бүртгэл зэргийг хянаж шалгаж ажилласан. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөлт маш муу, зарим барилгад хувийн хэрэг нээгээгүй, барилга нь газар эзэмших эрхийн гэрчилгээний кадастрт ороогүй зөрчлүүд байсан. Эдгээр зөрчлийг арилгах зааварчилгаа өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтээр тухайн газрууд гэрээ гэрчилгээг шинэчлэн ажилласан байна. Мөн санхүүгийн тайланд тусгаагүй газрууд газрын төлбөр төлдөггүй, зарим нь ийм газартайгаа мэдэхгүй байсан.</p> <p>Эх үүсвэр: МУЗГын 2018 оны 182 тогтоол, БХБСайдын 2018 оны 208 тушаал, ДУАИТХ 2018 оны 08/01 тогтоолыг үндэслэн үнэлгээг тооцсон.</p>
<b>Захиргаа аж ахуйн чиглэл</b>		
2	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b>  70376471 нээлттэй утсаар 10, Facebook хуудсанд ирсэн 6 иргэний асуултанд хариулт өгөв. 11-р багт байрлах гаражуудын нэгж талбарын хувийн хэргийн баяжуулалтыг хийлээ. 2022-06-10-ны өдөр цахим төвд ажиллав.</p> <p><b>Мэдээлэл технологийн чиглэлээр:</b>  Байгууллагын цахим хуудсанд байгууллагын 5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын 5-р сарын 4-р долоо хоногийн ажлын тайлан, 6-р сарын 1-р долоо хоногийн ажлын тайлан, 5-р сарын бичмэл тайланг байрлуулав. Серверийн өрөөний кондишны илүүдэл усыг асгаж цэвэрлэв.</p>

	<p><b>Нярав:</b> 10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 10 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 21 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 2 төрлийн 2 ширхэг бараа материал олгов. 5-р сарын шаардах хуудсаар олгосон бараа, материалын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв.</p>
--	---

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж